НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он


Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ундармаа
Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn

Аудитор: Л.Энх-Амгалан
Утас: 325093 Цахим хаяг:enkhamgalanl@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 45

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Л.БАТБАЯР ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

002021633

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I) | 2,430,453,064.00 | 3,268,157,919.80 |
| 33 | АВЛАГА | 2,430,453,064.00 | 3,268,157,919.80 |
| 33700 | Хөтөлбөртэй холбоотой авлага | 2,391,276,474.00 | 2,933,034,948.00 |
| 33703 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | 1,276,535,914.00 | 1,800,468,474.00 |
| 33705 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 431,584,738.00 | 493,444,700.00 |
| 33717 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 253,449,422.00 | 376,442,621.00 |
| 33720 | Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл | 129,200,000.00 | 63,500,000.00 |
| 33730 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 10,000,000.00 | 8,200,000.00 |
| 33718 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих | 290,506,400.00 | 190,979,153.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 34,386,590.00 | 330,332,971.80 |
| 33500 | Бусад авлага | 4,790,000.00 | 4,790,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 4,790,000.00 | 4,790,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | - | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II) | 2,430,453,064.00 | 3,268,157,919.80 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV) | 635,000.00 | 1,135,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 635,000.00 | 1,135,000.00 |
| 41300 | Өглөг | - | 500,000.00 |
| 41360 | Бусад өглөг | - | 500,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 500,000.00 |
| 41700 | Хөтөлбөртэй холбоотой өглөг | 635,000.00 | 635,000.00 |
| 41705 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 345,000.00 | 345,000.00 |
| 41718 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих | 290,000.00 | 290,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V) | 2,429,818,064.00 | 3,267,022,919.80 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,429,818,064.00 | 3,267,022,919.80 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,429,818,064.00 | 3,267,022,919.80 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,429,818,064.00 | 2,395,431,474.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 871,591,445.80 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V) | 2,430,453,064.00 | 3,268,157,919.80 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,448,522,860.00 | 2,362,595,939.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 196,648,860.00 | 189,423,939.00 |
| 1200 | Өмчийн орлого | 196,648,860.00 | 189,423,939.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 196,275,287.00 | 189,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 196,275,287.00 | 189,000,000.00 |
| 120009 | Бусад орлого /Үнэ төлбөргүй/ | 373,573.00 | 423,939.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,251,874,000.00 | 2,173,172,000.00 |
| 1310 | Улсын төсвөөс | - | 2,173,172,000.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | 2,173,172,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,251,874,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 2,251,874,000.00 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 1,778,720,223.00 | 1,491,004,493.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,778,720,223.00 | 1,491,004,493.20 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 80,306,153.20 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 80,306,153.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 80,306,153.20 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,778,720,223.00 | 1,410,698,340.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 230,823,455.00 | 167,550,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 186,615,287.00 | 167,550,000.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 44,208,168.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 835,208,544.00 | 721,624,131.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 835,208,544.00 | 721,624,131.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 712,688,224.00 | 521,524,209.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 712,688,224.00 | 521,524,209.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 669,802,637.00 | 871,591,445.80 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | - |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V) | 669,802,637.00 | 871,591,445.80 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,493,076,028.00 | 2,363,095,939.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 241,202,028.00 | 189,923,939.00 |
| 1200 | Өмчийн орлого | 241,202,028.00 | 189,923,939.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 240,828,455.00 | 189,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 196,620,287.00 | 189,000,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 44,208,168.00 | - |
| 120009 | Бусад орлого /Үнэ төлбөргүй/ | 373,573.00 | 923,939.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,251,874,000.00 | 2,173,172,000.00 |
| 1310 | Улсын төсвөөс | - | 2,173,172,000.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | 2,173,172,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,251,874,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,251,874,000.00 | - |
| 14 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО | 515,030,785.00 | 744,241,526.00 |
| 145 | Бусад орлого (олз) | 515,030,785.00 | 744,241,526.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 3,008,106,813.00 | 3,107,337,465.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,008,106,813.00 | 3,107,337,465.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 80,306,153.20 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 80,306,153.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 80,306,153.20 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,008,106,813.00 | 3,027,031,311.80 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 240,483,455.00 | 189,000,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 196,275,287.00 | 189,000,000.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 44,208,168.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 718,573.00 | 923,939.00 |
| 213404 | Хөрөнгийн | 718,573.00 | 923,939.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 859,216,561.00 | 1,029,583,163.80 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 859,216,561.00 | 1,029,583,163.80 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,907,688,224.00 | 1,807,524,209.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,907,688,224.00 | 1,807,524,209.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II) | (515,030,785.00) | (744,241,526.00) |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | - | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V) | - | - |
| 9 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 515,030,785.00 | 744,241,526.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 515,030,785.00 | 744,241,526.00 |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII) | 515,030,785.00 | 744,241,526.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | - | - |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан үр дүн | Бусад | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны 1-р сарын 1-ний үдэгдэл | 1,760,015,427.00 | - | 1,760,015,427.00 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 669,802,637.00 | - | 669,802,637.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,429,818,064.00 | - | 2,429,818,064.00 |
| 8 | 2022 оны 12-р сарын 31-ний үдэгдэл | 2,429,818,064.00 | - | 2,429,818,064.00 |
| 8 | 2023 оны 1-р сарын 1-ний үдэгдэл | 2,429,818,064.00 | - | 2,429,818,064.00 |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (34,386,590.00) | - | (34,386,590.00) |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,395,431,474.00 | - | 2,395,431,474.00 |
| 15 | Тайлант үеийн үр дүн | 871,591,445.80 | - | 871,591,445.80 |
| 16 | 2023 оны 12-р сарын 31-ний үдэгдэл | 3,267,022,919.80 | - | 3,267,022,919.80 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал | | ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | | ЗӨРҮҮ | |
|---|---|---|---|---|---|
| Код | Үзүүлэлт | төлөвлөгөө | гүйцэтгэл | тоо | хувь |
| **72102** | **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** | **2,173,172,000.00** | **1,887,830,362.20** | (285,341,637.80) | **86.9** |
| 80224 | Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс | 4,500,000.00 | 3,206,250.00 | (1,293,750.00) | **71.3** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,500,000.00 | 3,206,250.00 | (1,293,750.00) | **71.3** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,500,000.00 | 3,206,250.00 | (1,293,750.00) | **71.3** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,500,000.00 | 3,206,250.00 | (1,293,750.00) | **71.3** |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 4,500,000.00 | 3,206,250.00 | (1,293,750.00) | **71.3** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,500,000.00 | 3,206,250.00 | (1,293,750.00) | **71.3** |
| **82602** | **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих** | **401,705,000.00** | **377,958,000.00** | (23,747,000.00) | **94.1** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 401,705,000.00 | 377,958,000.00 | (23,747,000.00) | **94.1** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 401,705,000.00 | 377,958,000.00 | (23,747,000.00) | **94.1** |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 401,705,000.00 | 377,958,000.00 | (23,747,000.00) | **94.1** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 401,705,000.00 | 377,958,000.00 | (23,747,000.00) | **94.1** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 401,705,000.00 | 377,958,000.00 | (23,747,000.00) | **94.1** |
| **82619** | **Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ** | **36,587,000.00** | **26,299,550.00** | (10,287,450.00) | **71.9** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 36,587,000.00 | 26,299,550.00 | (10,287,450.00) | **71.9** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 36,587,000.00 | 26,299,550.00 | (10,287,450.00) | **71.9** |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,587,000.00 | 26,299,550.00 | (10,287,450.00) | **71.9** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,587,000.00 | 26,299,550.00 | (10,287,450.00) | **71.9** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,587,000.00 | 26,299,550.00 | (10,287,450.00) | **71.9** |
| **82620** | **Хөдөлмөрт бэлтгэх сургалт** | **26,950,000.00** | **19,150,000.00** | (7,800,000.00) | **71.1** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 26,950,000.00 | 19,150,000.00 | (7,800,000.00) | **71.1** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 26,950,000.00 | 19,150,000.00 | (7,800,000.00) | **71.1** |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 26,950,000.00 | 19,150,000.00 | (7,800,000.00) | **71.1** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,950,000.00 | 19,150,000.00 | (7,800,000.00) | **71.1** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,950,000.00 | 19,150,000.00 | (7,800,000.00) | **71.1** |
| **82621** | **Аж ахуй эрхлэлтийг** | **1,268,000,000.00** | **1,236,900,659.00** | (31,099,341.00) | **97.5** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **дэмжих санхүүгийн дэмжлэг** | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,268,000,000.00 | 1,236,900,659.00 | (31,099,341.00) | **97.5** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,268,000,000.00 | 1,236,900,659.00 | (31,099,341.00) | **97.5** |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,268,000,000.00 | 1,236,900,659.00 | (31,099,341.00) | **97.5** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,268,000,000.00 | 1,236,900,659.00 | (31,099,341.00) | **97.5** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,268,000,000.00 | 1,236,900,659.00 | (31,099,341.00) | **97.5** |
| **82622** | **Түр ажлын байрыг дэмжих** | **353,680,000.00** | **147,216,000.00** | (206,464,000.00) | **41.6** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 353,680,000.00 | 147,216,000.00 | (206,464,000.00) | **41.6** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 353,680,000.00 | 147,216,000.00 | (206,464,000.00) | **41.6** |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 353,680,000.00 | 147,216,000.00 | (206,464,000.00) | **41.6** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 353,680,000.00 | 147,216,000.00 | (206,464,000.00) | **41.6** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 353,680,000.00 | 147,216,000.00 | (206,464,000.00) | **41.6** |
| **82623** | **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал** | **81,750,000.00** | **77,099,903.20** | (4,650,096.80) | **94.3** |
| 12 | Татварын бус орлого | 81,750,000.00 | 77,099,903.20 | (4,650,096.80) | **94.3** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 81,750,000.00 | 77,099,903.20 | (4,650,096.80) | **94.3** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 81,750,000.00 | 77,099,903.20 | (4,650,096.80) | **94.3** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 81,750,000.00 | 77,099,903.20 | (4,650,096.80) | **94.3** |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 81,750,000.00 | 77,099,903.20 | (4,650,096.80) | **94.3** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 81,750,000.00 | 77,099,903.20 | (4,650,096.80) | **94.3** |
| **3** | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | | | - | |
| | Улсын төсвөөс санхүүжих | 2,173,172,000.00 | 1,887,830,362.00 | (285,341,638.00) | 86.9 |
| 12000 | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | (285,341,637.80) | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлант жилийн дүн |
|---|---|---|
| 72102 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 4,500,000.00 |
| 82623 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал | 4,500,000.00 |
| | Татварын бус орлого | 4,500,000.00 |
| | Нийтлэг татварын бус орлого | 4,500,000.00 |
| 1200042 | Төсөвт байгууллагын өөрийн орлого /Туслах/ | 4,500,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,500,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,500,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 4,500,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,500,000.00 |
| 12000 | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

### Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,240,533.1 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруууллаа.

Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг дансны гүйлгээг 21,450.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн бусад орлогын дүнг 500.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 1,218,583.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Эдгээр нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 423,165.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд 7 зөвлөмж өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Урсгал зардалтай холбоотой асуудал**

*<u>1.1 Илрүүлэлт</u>*: Нийтийг хамарсан ажлын төсөлд бий болох түр ажлын байрны тоо, гүйцэтгэх ажлын зардал, санхүүгийн тооцоо, төлөвлөгөө хэрэгжүүлэх байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргаж үнэлээгүй, иргэдийн цалин хөлс,

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн зардлыг ажилласан цагаар тооцож 42 иргэнд 12,600.0 мянган төгрөгийн хөлс олгосон байна.

*Өгсөн зөвлөмж:* Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг ажил хийж дууссаны дараа үр дүнг тооцож олгож байх.

*1.2 Илрүүлэлт* Түрээсийн төлбөрийн 20,550.0 мянган төгрөгийг нөхөн олгохдоо тухайн төлбөрийн төлсөн баримтыг татварын И баримтаар баталгаажуулаагүйгээс дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай нотлох баримт хангалтгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэхдээ тухайн төлбөр авагчийн орлогыг баталгаажуулсан татварын и-баримт, төлбөр төлсөн баримтуудад үндэслэн олгож байх.

*1.3 Илрүүлэлт:* Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан ахмадуудын урамшуулалд анхан шатны баримт хангалтгүй, чиг үүрэг бүхий бусад байгууллагуудаар баталгаажуулаагүй баримтаар 30,884.0 мянган төгрөг олгосон.

*Өгсөн зөвлөмж:* Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр аргазүйгээр хангуулах ажлын удирдамж чиглэл батлуулан хүүхэд хамгаалагчийг ажиллуулах байршил бүхий төлөвлөгөө гаргаж, хяналт тавьж ажиллах.

*1.4 Илрүүлэлт:* Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хөлс 5,500.0 мянган төгрөгийг холбогдох байгууллагуудаар баталгаажуулаагүй баримтаар олгосон.

*Өгсөн зөвлөмж:* Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ажлыг баталгаажуулан үйлчилгээний хөлсийг олгож байх.

Эдгээр зөрчлүүд нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн байна.

2. **Хөтөлбөрийн авлага данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдээс нас барсан 10 иргэний 23,299.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл байна. Энэ нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Хариуцах эзэнгүй болсон авлагыг шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах.

3. **Татаас санхүүжилтийн авлага данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Татаас санхүүжилтийн 330,332.9 мянган төгрөгийн авлагыг төрийн сан, Сангийн яамтай тооцоо нийлээгүй байна. Энэ нь тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавар бий болгосон ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

зүйлийн 20.1.4 хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх заалтыг зөрчсөн байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Авлагын үлдэгдлийг төрийн сантай тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнаж байх.

4. **Бусад асуудалтай холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт</u>:* Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.7 заасан "... Бичил үйлдвэр эрхлэгч болон нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих" арга хэмжээнд хуулийн 12.8-д заасан бизнес инкубацийн үйлчилгээг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д заасан бизнес инкубацийн үйлчилгээг дараах (12.8.1, 12.8.2, 12.8.3, 12.8.4, 12.8.5 заалтууд) хэлбэрээр дэмжинэ заалтыг хэрэгжүүлээгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг сургалтад хамруулах, төсөл боловсруулахад зөвлөгөө өгөх, туслах, мэдээллээр хангах үйлчилгээг үзүүлж дэмжиж байх.

## дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангийн улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг дансны дүнг дутуу илэрхийлсэн. | 1 | 21,450.0 | 1 | 21,450.0 | | | 1 | 21,450.0 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн бусад орлогын дүнг дутуу илэрхийлсэн | 1 | 500,0 | 1 | 500,0 | | | 1 | 500,0 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг илүү тайлагнасан | 1 | 1,218,583.1 | | | 1 | 1,218,583.1 | 1 | 1,218,583.1 | | | | |
| **Дүн** | **3** | **1,240,533.1** | **2** | **21,950.0** | **1** | **1,218,583.1** | **3** | **1,240,533.1** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нийтийг хамарсан ажлын төсөлд бий болох түр ажлын байрны тоо, гүйцэтгэх ажлын зардал, санхүүгийн тооцоо, төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргаж үнэлээгүй, | 1 | 12,600.0 | | | | | 1 | 12,600.0 | | | | |
| Түрээсийн төлбөрийг нөхөн олгохдоо тухайн төлбөрийн төлсөн баримтыг татварын И баримтаар баталгаажуулаагүй, нотлох баримт хангалтгүй | 1 | 20,550.0.0 | | | | | 1 | 20,550.0 | | | | |
| Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан ахмадуудын урамшууллалд анхан шатны баримт хангалтгүй, хамаарал бүхий бусад байгууллагуудаар баталгаажуулаагүй. | 1 | 30,884.0 | | | | | 1 | 30,884.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хөлсийг холбогдох байгууллагу удаар баталгаажуулаагүй. | 1 | 5,500.0 | | | | | 1 | 5,500.0 | | | | |
| Татаас санхүүжилтийн 330,332.9 мянган төгрөгийн авлагыг төрийн сан, Сангийн яамтай тооцоо нийлээгүй, төлөгдөх эсэх нь эргэлзээтэй | 1 | 330,332.9 | | | | | 1 | 330,332.9 | | | | |
| Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдээс нас барсан 10 иргэний 23,299.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй | 1 | 23,299.0 | | | | | 1 | 23,299.0 | | | | |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.7 заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | 7 | 423,165.9 | | | | | 2 | 423,165.9 | | | | |